

ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ, АНГИЛАХ, ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, СЭРГЭЭН АШИГЛАХ, УСТГАХ, БУЛШЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмаар айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагаас үүсэх хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах, ангиллын дагуу цуглуулж, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах, нийтийн эдэлбэр газрыг цэвэрлэх үйл ажиллагааг эрхлэхэд үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Журам нь Хог хаягдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомж болон бусад эрх зүйн актаас бүрдэнэ.

1.3. Журмыг Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт ажиллаж амьдарч байгаа иргэд, аж ахуй нэгж, байгууллагууд, журмын хэрэгжилт, хяналтыг хариуцсан эрх бүхий албан тушаалтнууд дагаж мөрдөнө.

1.4. Журмын хэрэгжилтэд бүх шатны Засаг дарга, улсын байцаагч, цагдаа, хог хаягдлын олон нийтийн байцаагч хууль тогтоомжоор эрх олгогдсон албан тушаалтан, гэрээгээр эрх олгосон төрийн бус байгууллага, олон нийтийн хяналтыг иргэдийн бүлэг, иргэн тавина.

ХОЁР. БАРИМТЛАХ ЗАРЧИМ, ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

2.1. Хог хаягдал үүсгэгч болон энэхүү харилцааг зохицуулах эрх бүхий этгээд үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална.

2.1.1. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, амьдралын энгийн зан үйл, хэв загварыг хэвшүүлэх, ангилах, эдийн засгийн эргэлтэд оруулах

2.1.2. Хамгийн бага хэмжээгээр булаах

2.1.3. Байгаль орчинд ээлтэй, нийгмийн эрүүл мэндэд харшлахгүй байх

2.1.4. Дэвшилтэт технологи, шинэлэг санаачилгыг нэвтрүүлэх

2.1.5. Салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах

2.1.6. Бохирдуулагч төлөх, үүсгэгч нь өөрөө хариуцах.

2.2. Ерөнхий шаардлага

2.2.1.Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагааг аймаг, сумын Засаг даргатай гэрээ байгуулж бүртгүүлсэн эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллага гүйцэтгэнэ.

2.2.2.Аймаг, сумын Засаг даргатай гэрээ байгуулсан эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ чиглэлийн үйл ажиллагаандаа холбогдох хууль, журам энэ чиглэлээр батлагдан гарсан Монгол Улсын стандартыг мөрдөн ажиллана.

ГУРАВ. АЙМАГ, СУМ, БАГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЧИГ ҮҮРЭГ

3.1. Аймгийн Засаг даргын чиг үүрэг

3.1.1.Журмын хэрэгжилтийг хангаж, үр дүнг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тайлагнах

3.1.2.Журмыг хэрэгжүүлэхэд сум, багийн Засаг дарга болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг бодлогоор дэмжин ажиллах.

3.2. Сумын Засаг даргын чиг үүрэг

3.2.1.Сумын хилийн цэс доторх нийтийн эдэлбэр газарт хамаарах гудамж, зам талбайн жагсаалт батлах

3.2.2.Бүх нийтийн цэвэрлэгээнд хамрагдах сумын нутаг дэвсгэрийн гудамж, зам, талбай, ногоон бүсийн зураглалыг гаргаж, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуй нэгж, байгууллага, их, дээд сургууль, коллеж, ерөнхий боловсролын сургуулиудад хариуцуулах

3.2.3.Хог хаягдлын талаарх сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагуудтай хамтарч зохион байгуулах

3.2.4.Олон нийтийг хамарсан наадам, фестиваль, тоглолт, цэнгүүн зохион байгуулах үед гурваас доошгүй төрлөөр ангилан ялгах хогийн сав байршуулж, цэвэрлэгээ үйлчилгээг хийх зардлыг тухайн жилийн төсөвт тусгуулах

3.2.5.Иргэн бүр хог хаягдлын дүрмийг хэрэгжүүлдэг байх дадал, хандлага бий болгох нөлөөллийн ажлыг өргөн хүрээнд зохион байгуулах

3.2.6.Сумын хэмжээнд журмын хэрэгжилтийг хангуулах, ил задгай хог хаягдал үүсэхгүй байх арга хэмжээг зохион байгуулах

3.2.7.Сумын нутаг дэвсгэрт хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй иргэн, аж ахуй нэгжийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр нээлттэй сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажиллуулах

3.2.8.Аж ахуй нэгж, байгууллага, иргэний төлөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийг Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2-т заасан хэмжээгээр тооцож авахад хяналт тавих, үйлчилгээний хураамжийн орлого төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэх

3.2.9.Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.7, 9.4.14-д заасан олон нийтийн байцаагч ажиллуулах, шаардагдах төсвийг тухайн жилийн төсөвт тусгах

3.2.10.Сумын нутаг дэвсгэрт орших хаягдал цуглуулах цэгүүд дээр эх үүсвэр дээрх ангилан ялгалт хийлгүүлж, ачиж тээвэрлэх шугамыг 2 салгаж дахивар, бусад хаягдлыг ангилж тээвэрлэдэг тогтолцоог бий болгох, дахиварын тээврийн төвийг байгуулах байршлыг тогтоох

3.2.11.Зам талбайн цэвэрлэгээг батлагдсан тарифыг үндэслэн цэвэрлэгээний зардлыг тусгах

3.2.12.Бүх нийтийн их цэвэрлэгээг улирлын байдлаас хамаарч тухай бүр зохион байгуулах.

3.3. Багийн Засаг даргын чиг үүрэг

3.3.1.Багийн иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудыг хог хаягдлын чиглэлээр зохион байгуулж буй сургалтанд хамруулж оролцоог хангах

3.3.2.Хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх хуваарийн хэрэгжилтэд хяналт тавих

3.3.3.Овор хэмжээ ихтэй хог хаягдлыг татан зайлуулах, үйлчилгээний хураамж төлүүлэхэд олон нийтийн байцаагч, мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж гэрээ байгуулан хамтран ажиллах.

ДӨРӨВ. АЖ АХУЙ НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБОО, ИРГЭДИЙН ЭРХ ҮҮРЭГ

4.1.Аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг

4.1.1.Аж ахуй нэгж, байгууллага орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газар, зам талбайн хог хаягдал, цас мөсийг цэвэрлэх

4.1.2.Журмын 4.1.1-т заасан үүргийг гүйцэтгэхгүй тохиолдолд сумын Засаг дарга тохижилт үйлчилгээний байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд гарсан зардлыг тухайн аж ахуйн нэгж, байгууллага хариуцах

4.1.3.Аж ахуйн нэгж, байгууллага нь үйл ажиллагааны үе шат бүрдээ үүсэж буй хог хаягдлын цогц менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж үр дүнгээ тайлагнадаг, нийгмийн хариуцлагын хэрэгжүүлж бүх нийтийн цэвэрлэгээнд ажилтан, албан хаагчдыг хамруулах, холбогдох зардлыг гаргаж цэвэрлэгээний багаж, хэрэгслээр хангах

4.1.4.Сум, багаас зохион байгуулж буй хог хаягдлын талаарх сургалтад хамрагдах, байгууллага дотроо хог хаягдлын менежментийн сургалтыг зохион байгуулж, ажиллагсдадаа зөв дадал хандлагыг түгээн дэлгэрүүлэх

4.1.5.Аж ахуй нэгж, байгууллага нь жорлон, гар угаах газартай, гадна талбайдаа дахивар, булшлах хог хаягдал, хүнсний хог хаягдал гэсэн 3 төрлөөр хог

хаягдал ангилах, хадгалах, ачиж тээвэрлэхэд хялбар шаардлага хангасан сав, талбайтай байх

4.1.6.Хог хаягдлын саванд ангиллыг заасан стандарт тэмдгийг байршуулах

4.1.7.Хог хаягдлын сав хогийг ангилж хийх, хадгалахад хялбар хийцтэй байх

4.1.8.Хогийн савыг тогтмол цэвэрлэж сард нэгээс доошгүй удаа угааж, ариутгадаг байх

4.1.9.Барилга байгууламжийг өргөтгөх, шинээр барихдаа түүний зориулалт, хүн амын нягтрал, хог хаягдлын үүсэх хэмжээ, ангиллын төрлөөс хамаарч хог хаягдал хадгалах байр, талбайн байршлыг барилга, байгууламжийн зураг, төсөлд тусгасан байх

4.1.10.Овор хэмжээ их энгийн болон барилгын хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуульд зааснаар нэмэлт үйлчилгээний хөлс төлж, тохижилт үйлчилгээ хог тээврийн байгууллагаар тээвэрлүүлэх

4.1.11.Хог ачиж, тээвэрлүүлэх гэрээг хог тээврийн байгууллагатай байгуулж, хог хаягдлын овор хэмжээ эзлэхүүнийг багасгах боломжуудыг ашиглан, ангилж, ангиллын дагуу хогоо ачуулах ба гэрээнд хог ачих өдөр, цаг, байршил, давтамжийг тодорхой заах, гэрээнд заасан нөхцөлөөр хогоо ачаагүй тохиолдолд тухайн багийн Засаг даргад мэдээлэх, санал хүсэлт гаргах

4.1.12.Бүх нийтийн цэвэрлэгээний өдрүүдэд хариуцуулсан нийтийн эдэлбэр газар, зам талбайн хог хаягдал цас мөсийг цэвэрлэж, холбогдох байгууллагад хүлээлгэж өгөх.

4.2.Сууц өмчлөгчдийн холбооны эрх, үүрэг

4.2.1.Сууц өмчлөгчдийн холбоод харьяалах эзэмшлийн газар, зам талбайн хог хаягдал, цас мөсийг тухай бүр тогтмол цэвэрлэх

4.2.2.Харьяалж буй орон сууцныхаа иргэдэд ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь хэрхэн ангилан ялгах сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх өдөр, хуваарийн талаарх мэдээллээр хангах

4.2.3.Багийн Засаг дарга болон сумын Засаг даргын тамгын газрын холбогдох мэргэжилтэн хог хаягдлын тээвэр логистикийн компаниуд, сайн дурын сургагч багш нартай хамтран иргэдэд сургалт сурталчилгаа явуулах, нийтийн цэвэрлэгээнд оролцуулах

4.2.4.Иргэдийн эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж орц, байрны орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг хийх хугацааг тодорхой гаргаж хэвшүүлэх

4.2.5.Бүх нийтийн цэвэрлэгээнд харьяа орон сууцны иргэд болон орон сууцны нэг давхарт байрлах аж ахуйн нэгж байгууллагуудыг хамруулах

4.2.6.Иргэдийг сум, баг, мэргэжлийн холбоодоос зохион байгуулж буй хог хаягдлын сургалт, нөлөөллийн ажилд татан оролцуулах.

4.3.Иргэний эрх, үүрэг

4.3.1.Орон сууцны хорооллын айл өрх, оршин суугчид хамгийн бага хэмжээгээр хог үүсгэх, эх үүсвэр дээр хог хаягдлыг бууруулахад чиглэсэн энгийн амьдралын хэв загварт суралцах

4.3.2.Ахуйн хог хаягдлаа гэртээ зөв ангилах

4.3.3.Ангилсан хог хаягдлаа хог тээврийн байгууллагаас тогтоосон өдөр, цагт, заасан цэгт, гаргаж тавьж хэвших

4.3.4.Хог хаягдлыг орц болон зориулалтын бус цэгт хаясан, айл өрх, иргэнд шаардлага тавих

4.3.5.Үндсэн хуульд заасан иргэний журамт үүргээ биелүүлж бүх нийтийн их цэвэрлэгээний өдрүүдэд хариуцсан нийтийн эдэлбэр газар, гудамж, зам талбай, орц, байр орчмын хог хаягдлыг цэвэрлэх, эх үүсвэр дээр бууруулах, ангилахад чиглэсэн бусад ажлуудад оролцох

4.3.6.Гэр хорооллын айл өрхийн иргэн үнс нурмаа унтрааж, аюулгүй байдлыг ханган савлаж батлагдсан хуваарийн дагуу хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаар ачуулах

4.3.7.Иргэн, айл өрх сум, баг, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагаас зохион байгуулж буй хог хаягдлын талаарх сургалтад хамрагдах.

4.3.8.Хувийн хог хаягдлаа өөртөө хадгалж байгаад хамгийн эхэнд тааралдсан хогийн саванд ангиллын дагуу хийх, эсвэл гэрийнхээ хогийн саванд хаях.

ТАВ. НИЙТИЙН ЭДЭЛБЭР ГАЗАР, ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙГ ЦЭВЭРЛЭХ

5.1.Нийтийн эдэлбэр газар, гудамж, зам талбайн цэвэрлэгээг зам талбайн онцлог, улирлын байдлаас шалтгаалан гараар болон тусгай зориулалтын машин техникээр гүйцэтгэнэ.

5.2.Нийтийн эдэлбэр газар, гудамж, зам талбайн цэвэрлэгээг гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна.

5.2.1.Гудамж, зам талбайн хог хаягдлыг механикаар цэвэрлэх жижиг оврын тусгай зориулалтын авто машинтай байх

5.2.2.Ажилчдын ажлын хувцас солих өрөө, бие засах газар, халуун усанд орох нөхцөлийг бүрдүүлсэн түрээсийн болон өөрийн ажлын байртай байх

5.2.3.Зам талбайн цэвэрлэгээнд ажиллах шүүрт болон давс, бодис цацах тусгай зориулалтын авто машинтай байх ба автомашин нь стандартын шаардлага хангаж, тээврийн хэрэгслийн үзлэг, оношилгоонд хамрагдсан, байгаль орчин, агаарын чанарт сөрөг нөлөөгүй байх

5.2.4.Зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээнд ажиллах автомашин нь 5-аас дээш жилийн насжилттай бол агаарын бохирдлоос сэргийлэх зорилгоор автомашины түлш, яндангийн системд тусгай зориулалтын шүүлтүүр, тоног төхөөрөмж суурилуулсан байх

5.2.5.Цас мөс хайлуулах зориулалт бүхий бодис нөөцлөх шаардлага хангасан агуулахтай байх

5.2.6.Санхүүгийн чадавхтай байх, нийгмийн даатгал, татварын хугацаа хэтэрсэн өр, төлбөргүй байх

5.2.7.Цэвэрлэгээнд ашиглагдах автомашин, техник нь газар зүйн мэдээллийн (GPS) систем бүхий тоног төхөөрөмжтэй байх

5.3.Нийтийн эдэлбэр газар, гудамж, зам талбайд дараах зам, талбайг хамруулна.

5.3.1.Олон улс, улс, орон нутгийн чанартай автозам, замын байгууламж, тусгаарлах зурвас, гүүр, гүүрэн гарц, явган болон дугуйн зам, ногоон байгууламж, хайс, хашлага

5.3.2.Цэцэрлэгт хүрээлэн, талбай, хөшөө баримал, түүхийн дурсгалт газар, уран байгууламж

5.3.3.Орон нутгийн чанартай болон хотын доторх авто зам, замын байгууламж, авто зогсоол, явган болон дугуйн зам, ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн

5.4.Нийтийн эдэлбэр газар, зам талбайн цэвэрлэгээнд тавигдах шаардлага:

5.4.1.Аймаг, сумын төв гудамж, туслах зам талбайн цэвэрлэгээг өдөр бүр, хотоос алслагдсан болон хорооллын доторх зам талбайн цэвэрлэгээг долоо хоногт хоёроос доошгүй удаагийн давтамжтай цэвэрлэх

5.4.2.Гэнэтийн болон байгалийн давагдашгүй хүчин зүйл тохиолдсон үед ажлын цаг харгалзахгүйгээр ээлжээр цэвэрлэгээг хийх

5.4.3.Нийтийн эдэлбэр газар, зам, талбайд байрлуулсан хогийн савны хог хаягдлыг хогийн сав дүүрч, халихаас өмнө давтамж харгалзалгүйгээр суллаж цэвэрлэх

5.4.4.Цас мөс хайлуулах зориулалтаар цацсан давс, тусгай зориулалтын бодис бүхий цас, мөсийг ногоон байгууламжид хийхгүй байх, хариуцсан зам талбайн цас, мөсийг цас орсон өдрөөс хойш 48 цагийн дотор бүрэн цэвэрлэх

5.4.5.Авто болон явган хүний замын хайс, хашлага, нийтийн эдэлбэр газар, зам талбайн хогийн сав, сандал, бусад архитектурын уран байгууламжийг 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 10 дугаар сарын 1-ний өдрийн хооронд сард 1 удаа, бусад хугацаанд улиралд 1 удаа тус тус цэвэрлэж, ашиглалт хамгаалалтыг сайжруулах

5.4.6.Хатуу хучилттай авто зам, явган болон дугуйн замыг дулааны улиралд гар болон механикаар чийгшүүлэн цэвэрлэх

5.5.Нийтийн эдэлбэр газар, зам талбайн цэвэрлэгээг гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллага дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

5.5.1.Зам, талбайн үйлчлэгч, жолооч, ачигчдыг өвөл, зуны ажлын хувцас, хэрэгсэл, багаж, материалаар хангах

5.5.2.Зам талбайн цэвэрлэгээний хуваарь, дараалал, аргачлалыг батлуулж ажиллах

5.5.3.Өвлийн улиралд авто зам болон зам талбайг цас орсон даруйд цэвэрлэх, халтиргаа, гулгаа арилгах зориулалтын бодис, давсыг цацаж, замын хөдөлгөөн хэвийн үргэлжлэх нөхцөлийг бүрдүүлэх

5.5.4.Цас, зуд, үер усны аюулын үед ажиллах шуурхай ажиллагааны төлөвлөгөө, нөөц авто машин, багаж, тоног төхөөрөмж, материалын тоо хэмжээ, нөөцийн судалгааг гарган байгууллагын даргаар батлуулж, аймгийн онцгой комисст хүргүүлэх

5.5.5.Цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг зориулалтын саванд хийж, хог хаягдал тээвэрлэх автомашинд ачуулах

5.5.6.Журмын 4.1.2-т заасны дагуу төлбөртэйгөөр цэвэрлэгээ, үйлчилгээ үзүүлж, зардлыг гаргуулах.

ЗУРГАА.БҮХ НИЙТИЙН ИХ ЦЭВЭРЛЭГЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ

6.1.Бүх нийтийн их цэвэрлэгээнд дараах нийтийн эдэлбэр газар, гудамж, талбай, ногоон бүсийг хамруулна.

6.1.1.Олон улс, улс, орон нутгийн чанартай авто зам дагуух 50 хүртэл метрийн өргөн зурвас

6.1.2.Төмөр замын хамгаалалтын бүсээс гадагш 50 хүртэл метрийн өргөн зурвас

6.1.3.Голын голдирол, эрэг, түүний хамгаалалтын бүс

6.1.4.Ойн болон амралт зугаалгын бүс, зуслангийн газар

6.1.5.Орон сууц болон гэр хороолол доторх авто зам, явган зам, дугуйн зам, ногоон байгууламж, бичил цэцэрлэг, гудамж, тоглоомын талбай, жалга, суваг, үер усны хамгаалалтын далан, шуудуу

6.2. Нийтийн их цэвэрлэгээнд тавигдах шаардлага

6.2.1.Цэвэрлэсэн хог хаягдлыг ил задгай орхих, шатаахгүй байх

6.2.2.Цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг тусгайлан бэлтгэсэн уутанд хийж, уутны амыг боож хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх

6.2.3.Их дээд, политехникийн коллежийн оюутнууд болон ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдыг багш, эцэг эхийн хараа, хяналт доор нийтийн их цэвэрлэгээнд оролцуулж болно.

6.3.Бүх нийтийн цэвэрлэгээг улирлын онцлогийг харгалзан дараах төрлөөр гүйцэтгэнэ.

6.3.1.Хур хог цэвэрлэх, ачиж тээвэрлэх

6.3.2.Цас мөс цэвэрлэх, халтиргаа, гулгаа арилгах

6.3.3.Шарилж, хөл газрын хог ургамал цэвэрлэх

6.3.4.Нийтийн эдэлбэр газар, гудамж талбайн хайс хашлага, архитектурын жижиг байгууламжийг угааж, цэвэрлэх, будаж өнгийг сэргээх

6.3.5.Авто зам дагуух хог хаягдлын түүвэр цэвэрлэгээ

6.3.6.Нийтийн зориулалттай байрны орц, шатны хонгилын цонх, хаалгыг угаах

6.3.7.Орон сууцны байрны эргэн тойрон, хүүхдийн тоглоомын талбай,гэр хорооллын ил задгай хог хаягдлыг цэвэрлэх.

ДОЛОО.ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ АНГИЛАХ

7.1.Орон сууцны айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь дараах төрлөөр ангилна.

7.1.1.Дахин боловсруулах боломжтой хог хаягдал

7.1.2.Дахин боловсруулах боломжгүй хог хаягдал

7.1.3.Хүнсний органик хог хаягдал

7.2.Гэр хорооллын айл өрх, аж ахуй нэгж, байгууллага энгийн хог хаягдлыг дараах төрлөөр ангилна.

7.2.1.Дахин боловсруулах боломжтой хог хаягдал

7.2.2.Дахин боловсруулах боломжгүй хог хаягдал

7.2.3.Үнс, шаарга

7.2.4.Хүнсний органик хог хаягдал

7.3. Хог хаягдлын төрлийг дараах өнгөөр илэрхийлнэ.

7.3.1.Хуванцар, гялгар уут-Ногоон

7.3.2.Хөнгөн цагаан лааз, металл хаягдал-Улбар шар

7.3.3. Цаас-Цэнхэр

7.3.4. Шил-Цагаан

7.3.5. Хүнсний органик хаягдал-Бор

7.3.6. Бусад хог хаягдал-Хар

7.3.7. Аюултай хог хаягдал-Шар

7.4.Журмын 7.1-т заасан энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах төрлийг хог хаягдал дахин боловсруулах үйлдвэртэй уялдуулан аж ахуй нэгж, байгууллага, иргэд өөрсдийн санаачилгаар нэмэгдүүлэх

7.5.Нийтийн эдэлбэр газар, гудамж талбайд байршуулах хогийн савыг хүн ихээр төвлөрдөг, энгийн хог хаягдал их хэмжээгээр үүсдэг дараах байршлуудад байршуулна.

7.5.1. Төрөлжсөн зах, худалдааны төв

7.5.2. Соёл, спорт, үзвэр, үйлчилгээний газар

7.5.3. Цэцэрлэгт хүрээлэн, соёл амралтын газар.

НАЙМ.ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ

8.1.Орон сууцны хороолол, аж ахуй нэгжийн хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх үйлчилгээ эрхлэх тохиолдолд иргэн, хуулийн этгээд нь ачиж тээвэрлэх өөрийн болон түрээсийн тусгай зориулалтын автомашинтай байх

8.2.Гэр хорооллын хог, үнс тээвэрлэх үйлчилгээ үзүүлэх тохиолдолд задгай тэвштэй, өөрөө буулгагч төхөөрөмжтэй авто машинтай байх

8.3.Өөрийн болон түрээсийн машин техникийн засварын цех, дулаан байртай байх

8.4.Хог хаягдлын менежмент, ачаа тээврийн чиглэлээр ажилласан туршлагатай инженер, техникийн 2-оос доошгүй ажилтантай байх

8.5.Хог ачиж тээвэрлэх үйл ажиллагаанд оролцох машин техник нь газар зүйн мэдээллийн (GPS) систем бүхий тоног төхөөрөмжтэй байх

8.6.Хог тээврийн автомашин нь стандарт шаардлага хангаж, тээврийн хэрэгслийн үзлэг, оношилгоонд хамрагдсан, байгаль орчин, агаарын чанарт сөрөг нөлөөгүй байх

8.7.Хог хаягдал цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээний гэрээг сумын Засаг даргатай байгуулж, дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

8.7.1.Энгийн хог хаягдал цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд ажиллаж байгаа ажилчдыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан тухайн улиралд тохирсон ажлын хувцас, багаж хэрэгслээр хангах

8.7.2.Техникийн саатал, бусад тодорхой шалтгааны улмаас хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх хуваарийг зөрчихгүйн тулд нөөц машин техник, ачигчтай байх

8.7.3.Энгийн хог хаягдал ачиж тээвэрлэсний дараа тээврийн хэрэгсэл болон тэвшийг тогтмол цэвэрлэж, сар бүр ариутгал, халдваргүйжүүлэлт хийх

8.7.4.Хог хаягдлыг ачих, цуглуулахад дуут дохио, чанга яригч, хөгжмийг оройн 22.00 цагаас өглөөний 06.00 цагийн хооронд эмнэлэг, цэцэрлэг, сургууль болон орон сууцны хороолол дунд ашиглахгүй байх

8.7.5.Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээг тухайн сумын нэр, байгууллагын лого, бүртгэлийн дугаар бүхий харагдахуйц таних тэмдэгтэй авто машинаар гүйцэтгэх.

ЕС.ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ, СЭРГЭЭН АШИГЛАХ

9.1.Энгийн хог хаягдал дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагаа эрхлэгч дахин боловсруулсан болон сэргээн ашигласан хог хаягдлын мэдээ, тайланг тогтоосон хугацаанд аймгийн Байгаль орчны газарт ирүүлнэ.

9.2.Төвлөрсөн хогийн цэгт хүргэх боломжгүй суурин газарт өндөр даралт болон битүүмжлэл бүхий шаталтаас үүсэх утаа, тоос тортог, органик бохирдуулагч хорт хийг цэвэрлэх байгууламжтай, хог хаягдал шатаах зориулалтын, байгаль орчин сөрөг нөлөөгүй, байгаль орчны холбогдох стандарт шаардлагыг бүрэн хангасан бага, дунд оврын хог хаягдал шатаах байгууламж ашиглан дулаан, халуун ус үйлдвэрлэж хог хаягдлыг сэргээн ашиглах

9.3.Шатаах зуухны ачаалал, хүчин чадлаас илүү гарсан болон зуухны бүтцэд өөрчлөлт гарах, зуухны үйл ажиллагааны үзүүлэлт зөвшөөрөгдсөн хязгаараас давсан тохиолдолд шатаах зуухны үйл ажиллагааг зогсоож хэвийн нөхцөлд орсон тохиолдолд дахин ажиллуулах

9.4.Хог хаягдал дахин боловсруулах, сэргээн ашиглах төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгжид холбогдох хууль тогтоомжид заасны дагуу дэмжлэг үзүүлэх

9.5.Төрийн болон төрийн өмчийн оролцоотой, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуй нэгжүүд бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа хог хаягдлыг дахин боловсруулсан бүтээгдэхүүнийг нэн тэргүүнд сонгох

9.6.Овор хэмжээ ихтэй хаягдлыг татан зайлуулах, сэргээн ашиглахтай холбоотой харилцааг багийн засаг даргатай байгуулсан гэрээний дагуу оролцогч талууд хамтран ажиллаж эдийн засгийн эргэлтэд оруулна.

АРАВ.ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ УСТГАХ, БУЛШЛАХ

10.1.Байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх зорилгоор энгийн хог хаягдлыг устгахад дараах төрлийн үйл ажиллагаа хамаарна.

10.1.1.Хог хаягдлын төвлөрсөн цэгт эрх бүхий этгээд зориулалтын тоног төхөөрөмжөөр ландфилл аргаар газарт булшлах

10.1.2.Химийн аргаар зарим төрлийн хог хаягдлыг урвалд оруулж, боловсруулж устгах

10.1.3.Биологийн аргаар байгаль орчинд ээлтэй нөхцөлөөр боловсруулж устгах

10.1.4.Зориулалтын байгууламжинд байгальд ээлтэй технологиор хог хаягдлыг шатаах

10.1.5.Хог хаягдлыг халдваргүйжүүлж, байгальд хоргүй болгож устгах.

10.2.Энгийн хог хаягдлыг булшлах

10.2.1.Хог хаягдлын төвлөрсөн цэгт эрх бүхий иргэн, аж ахуй нэгж, байгууллага зориулалтын тоног төхөөрөмжөөр ландфилл аргаар булшлах

10.2.2.Хог хаягдлыг булшлах үйл ажиллагаа нь дэлхийн эрүүл мэндийн болон байгаль орчны холбогдох байгууллагуудаас гаргасан зөвлөмжийн дагуу байгаль орчинд хоргүй, нөхцөлөөр, ландфилл аргыг хэрэглэх

10.2.3.Эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь сэргээн ашиглах, дахин боловсруулах боломжгүй хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөгүй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга технологиор устгаж булшилна.

АРВАН НЭГ. ХАРИУЦЛАГА

11.1.Журмыг зөрчсөн иргэн, аж ахуй нэгж, байгууллагад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

11.2.Журмын хэрэгжилт, хяналтын хариуцлагыг зөрчсөн эрх бүхий албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

11.3.Хог хаягдлын үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэхтэй холбоотой маргааныг хоёр тал харилцан зөвшилцөж шийдвэрлэх ба зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

---o0o---

